

Илтгэлийн хураангуй:

1970-ААД ОН: ШОГ ЗОХИОЛЫН ҮЗЭЛ САНААНЫ ХӨГЖИЛ

А.Мөнх-Оргил

Монгол улс. МУИС-ийн Улаанбаатар сургууль.

Дорно дахин судлалын тэнхимийн эрхлэгч.

Хэлбичгийн ухааны доктор, дэд профессор

Монголын шинэ цагийн утга зохиол 1960-аад оноос бүхий л бүтцийнхээ хувьд шинэчлэгдэж, энэ шинэчлэл цаашдаа аргын эзэмшилт болон гүнзгийрсэн байдаг. Судалгааны төвшинд ч, туурвилзүйн хүрээнд ч ингэж харагддаг. *“1960-аад оноос хойших үе бол шинэ маягийн реалист уран зохиолын хөгжлийн маш чухал шат бөгөөд үндэсний уран зохиолын хувьд бүх үзүүлэлтүүдээрээ ялангуяа ур чадвараараа жигдрэн хөгжиж, мэргэжлийн төгс төгөлдөр бичгийн утга зохиол болон дэвшсэн үе гэж хэлж болох юм. Хэдийгээр нэг үзэл суртлын хүрээнд зохиолчид уран бүтээлээ бичиж байсан ч зохиол туурвилын үзэл санаа агуулга ихэд гүнзгийрч, хэлбэр баяжин, ур чадвар нь илт өссөн байна.”*¹ Утга зохиолын үндсэн гол төрөл зүйлүүд монголын утга зохиолын шинэ цагийн бүрэлдэхүүн хэдийнэ болж, төрөл зүйлүүд цааш ялгаран салж, түүний нь илрэл болсон бие төлөөлөгчид гарч, зохих арга туршлага бүтээж эхэлсэн юм.

Уран зохиолын хөгжлийн энэхүү шатны нэгэн илрэл нь шог хошин зохиолын хөгжлийн хандлага, үзэл санааны гүнзгийрэл болсон. Уран зохиолын хөгжлийн бодлогод тусгалаа олж, шог хошин зохиолын бие даасан түүвэр, эмхэтгэл гарч, “Инээдмийн өврийн дэвтэр” цуврал, “Шог хошин зохиолын дээж” зэргийг хэвлэн нийтэлж, мөн олон улсын шог хошин зохиолын уралдаанд манай зохиолчид оролцож, бүр зохих амжилт үзүүлэх болсноор батлагдана. Ц.Доржготов, Ж.Барамсай, Шаг.Цэнд-Аюуш нарын шог зохиолын төрлийн төлөөлөгчид төрөн гарч, илүү мэргэжлийн төвшинд дагнан бичиж, төрөл зүйлийн хувьд төлөвшүүлж эхэлсэн бөгөөд зохиол бүтээлүүдийн туурвилзүй, үзэл санааны хөгжлийг ХХ зууны монголын уран зохиолд гарч ирсэн үзэгдлийн хувьд тусгайлан тэмдэглэж болно.

Нэг талаас утга зохиолын хөгжлийн хууль зүй, туурвилзүйн асуудал нөгөө талаас хувь зохиолчийн уран сайхны өндөр мэдрэмж, уран чадвар, хувь амьдралд нь ч тохиолдож болох бодит хэрэг явдал нь тодорхой итгэл үнэмшлийг бүтээж тэдгээр нь биенээ нөхцөлдүүлэх, харилцан уялдах зүй тогтол байдаг. 1970-аад оны дунд үеэс хөнгөн егөөдөл, цагаан хошигнолоор бичиж эхэлсэн бөгөөд цаашид илүү өргөн хүрээнд асуудалд хандах, нийгмийн тогтолцоог, хувь хүний дотоод сэтгэлзүйн олон талыг нээх, нээхдээ шог инээдэмт байдлаар, тэр нь гүйцгйрүүлэн харахад эмгэнэлтэй зүйлд явж хүрдэг тийм уран сайхны туршлага бий болж, туурвилзүйн арга ур чадварын тодорхой нэгэн үе шат болсныг хэлж болно.

¹ Ц.Мөнх “Удиртгал”-“Монголын орчин үеийн уран зохиолын түүх” /III боть/ УБ., 1997. 4